



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (570)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Дэд хөтөлбөр батлах тухай*
- *Нийслэлийн нийтийн тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны арванхоёрдугаар сарын 5

№45 (570)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

733. Хувь хүний орлогын албан татварын тухай 1193

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

734. Цэвээн-Ойровын Бархаст Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 348 1194

735. Шархүүгийн Цэрэндоржид Монгол Улсын малын гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 349 1194

736. Мухагийн Каспийд Монгол улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 350 1195

737. Цэрэндоржийн Сарангэрэлд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 351 1195

738. Лувсаншаравын Норолхоосүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 352 1195

739. Төмөрбаатарын Нямхүүд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 353 1195

740. Галдангийн Вандандагвад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 354 1196

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

741. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 23 1196

742. Дэд хөтөлбөр батлах тухай Дугаар 25 1196

743. Нийслэлийн нийтийн тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 27 1199

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай 27<sup>1</sup> дугаар зүйл нэмсүгэй:

**"27<sup>1</sup> дугаар зүйл. Албан татварт хасалт хийх, буцаан олгох**

27<sup>1.1</sup>. Хувь хүн энэ хуулийн 16.1.12-т заасны дагуу албан татвар ногдох орлогын чөлөөлөлт, 24.6-д

заасны дагуу албан татварын хөнгөлөлт эдлэх бол тухайн хувь хүний холбогдох төсөвт төлөх албан татвар, албан татвар ногдох орлогыг хасч тооцож болно.

27<sup>1.2</sup>. Энэ хуулийн 27<sup>1.1</sup>-д заасны дагуу тухайн жилд хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс



их байвал татварын алба дараахь байдлаар зохицуулна:

27<sup>1</sup>.2.1. дараагийн сар, улирал, жилд төлөх албан татварт шилжүүлэн тооцох;

27<sup>1</sup>.2.2. хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт төлөх бусад төрлийн албан татварын төлбөрт шилжүүлэн тооцох.

27<sup>1</sup>.3. Энэ хуулийн 27<sup>1</sup>.1-д заасны дагуу тухайн жилд хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд албан татвар ногдвол зохих хувь хүний орлогын дүнгээс их байвал татварын алба дараагийн сар, улирал, жилд ногдох албан татвар ногдох орлогын дүнд шилжүүлэн тооцно.

27<sup>1</sup>.4. Илүү төлсөн албан татварыг дор дурдсан журмаар албан татвар төлөгчид буцаан олгоно:

27<sup>1</sup>.4.1. албан татварыг илүү төлсөн албан татвар төлөгч нь түүнийг буцаан авах хүсэлтээ татварын тооцоо хийж, тайлан тушаах үедээ харьяалах татварын албанд бичгээр гаргах;

27<sup>1</sup>.4.2. харьяалах татварын алба энэ хуулийн 27<sup>1</sup>.4.1-д зааснаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан

хянаж, буцааж олгох албан татварын хэмжээг тодорхойлон, энэ тухайгаа албан татвар төлөгчид бичгээр мэдэгдэж, албан татвар төлөгчийн нэр, регистрийн дугаар, харилцагч банкны дансны дугаар, буцааж олгох албан татварын хэмжээг тодорхойлсон саналыг ажлын 5 өдөрт багтаан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид хүргүүлэх;

27<sup>1</sup>.4.3. аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгж энэ хуулийн 27<sup>1</sup>.4.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан албан татварыг буцаан олгох.

27<sup>1</sup>.5. Албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

27<sup>1</sup>.6. Буцаан олгох албан татвар нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 20 хувиас хэтрэхгүй байна."

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

### Цэвээн-Ойровын Бархаст Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, эмнэлгийн практикт орчин үеийн эмчилгээний шинэ аргуудыг үр дүнтэй нэвтрүүлж, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулан, эх нялхсын эндэгдлийг бууруулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын сум дундын хүн эмнэлгийн их эмч Цэвээн-Ойровын Бархаст Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

### Шархүүгийн Цэрэндоржид Монгол Улсын малын гавьяат эмч цол хүртээх тухай

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, малын төрөл бүрийн өвчнийг оношлох, мал сүргийг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлж, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн лабораториудын чадавхийг дээшлүүлэх, Монгол Улсад мал эмнэлгийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд

орүүлсан хувь нэмрийг нь үнэлж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч Шархүүгийн Цэрэндоржид Монгол Улсын малын гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

### Мухагийн Каспийд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сурагчдын зурж дүрслэх авъяас чадварыг бүх талаар хөгжүүлэн улс, аймаг, олон улсын зургийн уралдаан тэмцээн, олимпиадад амжилттай оролцуулж, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх, залуу багш нарын заах арга, ур чадварыг дээшлүүлэхэд

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Булган сумын ахлах сургуулийн багш Мухагийн Каспийд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

### Цэрэндоржийн Сарангэрэлд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн, багш, сурагчдын ажиллаж, суралцах таатай орчинг бүрдүүлж, боловсролын шинэчлэлийг ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, сургалтын арга барилыг боловсронгуй болгоход оруулсан хувь

нэмрийг нь үнэлж Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургуулийн захирал Цэрэндоржийн Сарангэрэлд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

### Лувсаншаравын Норолхоосүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Орон нутгийн боловсролын байгууллагад олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, дунд сургуулийн багш, сурагчдад зориулсан ном, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэн, баруун монгол олон ястны хувцас хэрэглэгдэхүүний оёдол, эсгүүр, загвар, дизайн, уран хатгамал, чимэглэлийг судлан хөгжүүлэх, хүүхэд залуучуудад өвлүүлэн үлдээхэд оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Жаргалант сумын 6 дугаар дунд сургуулийн технологийн багш Лувсаншаравын Норолхоосүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

### Төмөрбаатарын Нямхүүд Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай

Төмөр замын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлтийн төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэх, зүтгүүр, вагоны ашиглалтыг сайжруулж, төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж УБТЗ-ын Хөдөлгөөний албаны орлогч дарга Төмөрбаатарын Нямхүүд Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

### Галдангийн Вандандагвад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Төмөр замын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж галт тэрэгний зам засварын чанарыг сайжруулан, шинэ техник технологи нэвтрүүлж, тээвэр үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, замын аж ахуйг бэхжүүлэх, төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэхэд оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж УБТЗ-ын Замын аж ахуйн албаны дарга Галдангийн Вандандагвад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

төрийн тусгай хамгаалалтад авахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болдод даалгасугай.

1. "Төрийн тусгай хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 127 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын "Нэг" дэх хэсгийн 14 дэх заалтын дараа "15.Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байр" гэж нэмсүгэй.

3. Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байрны хамгаалалтыг зохион байгуулахад шаардагдах 81.962.500 (наян нэгэн сая есөн зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөгийг 2009 оны улсын төсөвт тусган цаашид шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

2. Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байрыг 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
САНГИЙН САЙД**
**С.БАЯР  
С.БАЯРЦОГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж байх;

1. "Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

б/төрийн бус байгууллага болон хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагчдын оролцоог нэмэгдүүлэх;  
в/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж явц, дүнг жил бүрийн IV улиралд Засгийн газарт танилцуулж байх.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт үүрэг болгосугай:

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
САНГИЙН САЙД**
**С.БАЯР  
С.БАЯРЦОГТ**

а/дэд хөтөлбөрт тусгасан зорилт болон түүний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**
**Т.ГАНДИ**



Засгийн газрын 2008 оны 25 дугаар тогтоолын хавсралт

## НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ ХООЛ, ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсад амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд 1995 оны байдлаар хүн амын 36.3 хувийг эзэлж байсан бол 2002 онд 36.1 хувь, 2006 онд 32.2 хувь болж бага зэрэг буурсан байна. Засгийн газар хүн амын амьжиргааг дэмжих зорилгоор ядуу, эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, ядуу иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгох, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч байна.

Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний зарим төрлийг нэгтгэн зохицуулснаар

өрх, иргэдэд олгож байсан тэтгэмж, тусламжийн давхардал арилж, бэлэн мөнгөөр үзүүлж байсан идэвхгүй хэлбэрийн тусалцааг өрхийн ядуурлыг бууруулахад дэмжлэг болохуйц нийгмийн тусламж, үйлчилгээгээр солих боломж бий болсон.

Манай улсын хувьд хүнсний баталгаат байдал нь ядууралтай нягт холбоотой байна. Ядуурлыг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо хангалтгүй, орон нутгийн байгууллагын чадавхи сул хэвээр байна. Ядуу хүнийг тодорхойлох арга, аргачлалын тодорхойгүй байдал нь хүн ам, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн зорилтот бүлгийг тодорхойлоход хүндрэл учруулж байна.

Монгол Улсад инфляцийн түвшин 2008 он гарснаас хойш 24.6 хувь, 2008 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.2 хувь хүрээд байна. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 9 дүгээр сарын байдлаар оны эхнээс 30.4 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.2 хувьд хүрээд байна /Хүснэгт/.

### Хүснэгт. Бүтээгдэхүүн болон үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт

	2004	2005	2006	2007	2008 оны 9 дүгээр сарын байдлаар
Хэрэглээний үнийн ерөнхий индекс	11.0	9.5	6.0	15.1	24.6
Хүнсний бүтээгдэхүүн	15.2	15.6	3.3	24.6	30.4
Хувцас, гутал, нэхмэл эдлэл	1.3	-0.4	7.5	3.0	10.5
Гэр ахуйн бараа, түлш, цахилгаан	3.9	4.3	8.7	11.0	12.8
Тээвэр, харилцаа, холбооны үйлчилгээ	21.9	5.9	12.1	10.6	22.3

Инфляцийн өсөлтийн гуравны хоёр нь хүнсний бүтээгдэхүүн ялангуяа хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүн болох мах, гурилын үнийн өсөлтөөс үүдэлтэй байна.

Манай улс махнаас бусад хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортлоор авч хэрэгцээгээ хангаж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хамгийн их нөлөөлж байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох үндсэн нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өсч байгаа ч хүн амын ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, тэдний орлогоос хамаарч хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт харилцан адилгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь айл өрх болон хувь хүмүүст сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд үндд хамгийн их өртөж байгаа нь ядуу өрхийн жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл хүүхэдтэй эхчүүд,

5 хүртэлх насны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардлагатай асран хамгаалах хүнгүй ахмад настан байна. Түүнчлэн орон гэргүй, ажилгүй, төв суурин газар шилжин суурьшсаны улмаас нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжгүй болсон иргэд, ядуу иргэд үнийн өсөлтөд хамгийн ихээр өртөж байна. Иймд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс тэднийг хамгаалж, нийгмийн баталгаат байдлыг хангах зорилгоор "Нийгмийн эмзэг хэсэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр" /цаашид "дэд хөтөлбөр" гэх/ хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

### Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, хугацаа, санхүүжилт

2.1. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өндөр өсөлтөөс шалтгаалсан эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, урьдчилан

тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасгай.

2. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэх ажлыг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасгай.

3. Нийслэлийн нийтийн тээвэр, замын хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Т.Билэгтэд даалгасгай:

а/нийтийн тээврийн зорчигч урсгалын судалгааг нарийвчлан гаргаж, үйлчилгээний чиглэлийн давхцалыг бууруулах, маршрут болон замын хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулж, нийтийн тээвэр саадгүй зорчих нөхцөл бүрдүүлэн 2009 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөх;

б/нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн болон таксийн зогсоол, хийн түлш түгээх станц, нийтийн тээврийн авто аж ахуйн барилга байгууламж, авто вокзал барих асуудлыг 2009 онд багтаан шийдвэрлэх;

в/нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газруудыг хувьцаат компани болгон өөрчилж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оруулах таатай нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

г/цагдаа, гал түймэртэй тэмцэх, түргэн тусламж зэрэг үйлчилгээг саадгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хотын орон сууцны болон гэр хорооллын доторхи замын хөдөлгөөнийг хаасан хаалт, хашаа, саадыг арилгах арга хэмжээ авах;

д/хайс, хашлага барих замаар тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн хөдөлгөөнийг тусгаарлаж зам тээврийн осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

е/хотын захад ачааны терминал бүхий үйлчилгээний цогцолбор барьж, ачааны автомашиныг өдрийн цагаар Улаанбаатарт орох хөдөлгөөнийг хязгаарлах;

ж/нийслэлийн хүнс, барааны төвлөрсөн захуудын ажиллах цагийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ялгавартай тогтоож замын хөдөлгөөний түгжрэлийг багасгах арга хэмжээ авах.

4. Замын зорчих хэсэгт тэмдэг, тэмдэглэлийн заалт зөрчин хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг ачиж зөөвөрлөх зэргээр хөдөлгөөний түгжрэлийг багасгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Т.Билэгт нарт даалгасгай.

5. Замын цагдаагийн албаны хүн хүч, техник хэрэгслийг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын гудамж, замыг 24 цагийн байнгын хяналтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасгай.

6. Ажилтнуудын эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулах, үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлэх, цалин хөлс, урамшууллыг оновчтой тогтоох зэрэг асуудлыг хөдөлмөрийн болон хамтын гэрээнд тусган хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙД**

**Х.БАТТУЛГА**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс: 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 1